

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

**Төслийн нэр: УЛААНБАДРАХ СУМАНД “380 КВТ-ЫН ЦАХИЛГААН ҮҮСГЭВЭР
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ” ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛ**

Төслийн дугаар: ДГАУБСЗДТГ/202004011/

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Тендер зарлах огноо: 2020-05-22

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газарт **“380 квт-ын цахилгаан үүсгэвэр” нийлүүлэгчийг** сонгон шалгаруулах тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны стандарт, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 10 цаг 10 минутанд нээнэ.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газар

Утас: 99829812, 99291382

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Оролцогч компанийн танилцуулга
 - (в) Бараа нийлүүлэх хуваарь;
 - (г) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;
 - (д) Ижил төрлийн бараа, нийлүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар, хүлээлгэн өгсөн акт 2018-2019 оноор
 - (е) Шаардлагатай тусгай зөвшөөрөл “шаардахгүй”
 - (ё) -Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /гадаад худалдаа эрхлэх/ чиг үүрэгтэй байх.
-Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл
-Харъяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
- Татварын тайлан /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх
- Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/
-Гэрээг гүйцэтгэгч удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар.
/ж/ Тендерийн баталгаа ирүүлэхгүй.
4. Тогтмол үнэ
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан

арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- | | |
|--|--|
| <p>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p> | <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> |
| <p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p> | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <i>ТШӨХ-д</i> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| <p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</p> | <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТООЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТООЗ 1.1	<p>Сүүлийн <i>1</i> жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</p> <p>Сүүлийн 1 жилийн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт/;</p>
ТООЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбадрах сум 4-р баг, Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Сумын Засаг даргын орлогчийн албан өрөөнд</i></p> <p>Тендер хүлээн авах хаяг: www.tender.gov.mn</p> <p>Огноо: <i>2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 00 минут</i></p>
ТООЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбадрах сумын 4-р баг, Засаг даргын Тамгын газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Улаанбадрах сумын Засаг даргын орлогчийн албан өрөөнд</i></p> <p>Огноо: <i>2020 оны 05 дугаар сарын 29-ний өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 10 минут /www.tender.gov.mn/ цахим хаягаар нээнэ.</i></p>
ТООЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: ДГАУБСЗДТГ/202004011/</p>

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛААНБАДРАХ СУМАНД “380 КВТ-ЫН
ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСГЭВЭР” ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. 60кВт-ын хүчин чадалтай 1 ширхэг, 380 кВт-ын хүчдэл гаргах
2. Орчин үеийн түлш зарцуулалт, дуу чимээ багатай байх
3. Зориулалтын бүхээгтэй, зөөвөрлөх боломжтой байх /Зурагт заасны дагуу/
4. Үйлдвэрийн гарал үүслийн гэрчилгээ, ашиглалтын заавартай байх /монгол хэлээр/
5. Асаалтын систем нь автомат байх
6. Хянах самбар нь электрон, бүх мэдээллийг хянах боломжтой байх
7. Монгол Улсын цаг уурын нөхцөлд тохирсон байх +40, -25с
8. Хүнд шингэн түлшээр ажилладаг байх /дизель түлш/
9. Шингэний хөргөлттэй хөдөлгүүртэй байх

380-ын кВт-ын зураг /Зургийн дагуу бүхээгтэй зөөвөрлөх боломжтой байх/



ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Гүйцэтгэх ажил нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Ажил гүйцэтгэх хугацаа ____ хэд хоног байна.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [Ажлын 21] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөж тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ. |

- | | |
|--|--|
| 9. Алданги
оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ
биелүүлээгүй-гээс гэрээг
цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг
шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах
болон
турших
(ГЕН – 1) | 1.1. [Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Дорноговь аймгийн Улаанбадрах сумын 4 дүгээр багийн “Төвийн гудамжид камер угсарч суурилуулах ажил” ДГАУБСЗДТГ/202004011/ |
| 2. Барааны
нийлүүлэлт
ба баримт
бичгийн
бүрдүүлэлт
(ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"> 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт; 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[1 жилийн баталгаат хугацаатай байна]
- 4. Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹** 9.1. Алданги оногдуулах хувь: **[0.1%]**

Алдангийн нийт дүн: **[10%]**
-

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]
